



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/150

Хэрлэн сум

Хэнтий аймгийн Улаан загалмай
хороонд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Монголын Улаан загалмайн нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн Улаан загалмай хороотой 2023 онд байгуулсан гэрээний дагуу хүмүүнлэгийн арга хэмжээний төлөвлөгөө хэрэгжүүлэхэд 10,000,000 (арван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг “Улаан загалмайн хороонд дэмжлэг” зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ